



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өгийнуур сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2024/17/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг  
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)

Аудитор Л.Соёлмөнх  
Утас: 7033-3019

Цахим хаяг: [Soyolmunkhl@audit.gov.mn](mailto:Soyolmunkhl@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.25 № 156

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН  
ӨГИЙНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ш.ҮҮРЦАЙХ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өгийнуур сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Өгийнуур сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

### Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 107, 489, 491 дүгээр тогтоол, 2023 оны 241 дүгээр тогтоол, Архангай аймгийн Засаг даргын А/74 дүгээр захирамжийн дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой цалингийн сан 39.4 нэмэгдсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Сумын Засаг дарга нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт,

төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс **86.6** хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	627,504.9	679,866.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	286,422.6	388,193.0
33	АВЛАГА	296,066.3	238,118.2
35	БАРАА МАТЕРИАЛ	45,016.0	53,555.6
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,314,504.4	1,489,756.2
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,314,504.4	1,489,756.2
39200	Биет хөрөнгө	1,265,205.0	1,440,956.8
39300	Биет бус хөрөнгө	49,299.4	48,799.4
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	1,942,009.4	2,169,623.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	1,942,009.4	2,169,623.0
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,942,009.4	2,169,623.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	433,914.4	433,914.4
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,242,716.2	1,498,143.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	265,378.8	237,565.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	1,942,009.4	2,169,623.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,498,155.9</b>	<b>1,814,163.7</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>405,416.0</b>	<b>386,572.8</b>
110	Орлогын албан татвар	219,842.7	251,759.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	219,823.8	251,576.8
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	18.9	182.7
113	Хөрөнгийн албан татвар	88,630.4	110,086.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	96,942.8	24,726.9
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>491,439.3</b>	<b>311,050.6</b>
120	Нийтлэг татварын бус орлого	491,439.3	311,050.6
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>601,300.6</b>	<b>1,116,540.3</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>810,062.1</b>	<b>1,295,753.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>810,062.1</b>	<b>1,295,753.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>782,231.5</b>	<b>1,279,724.7</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,709.2	455,973.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,082.1	57,086.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,835.8	50,785.5
2104	Хангамж, бараа материалын зардал	39,202.5	55,114.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,248.5	7,678.7
2107	Томилолт, зочны зардал	5,281.5	11,118.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,105.8	452,417.2

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,766.2	189,551.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,830.6	16,028.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	688,093.7	518,410.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,946,095.4	290,796.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,258,001.7	227,613.7

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,116,690.7	1,608,364.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	405,416.0	386,572.8
110	Орлогын албан татвар	219,842.7	251,759.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	219,823.8	251,576.8
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	18.9	182.7
113	Хөрөнгийн албан татвар	88,630.4	110,086.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	96,942.8	24,726.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,932.2	16,399.8
1181	Газрын төлбөр	11,520.2	2,767.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	65,490.5	5,560.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,974.1	105,251.7
120	Нийтлэг татварын бус орлого	109,974.1	105,251.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	601,300.6	1,116,540.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	687,931.4	1,145,388.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,931.4	1,145,388.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	659,753.9	1,129,359.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,709.2	455,973.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,082.1	57,086.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,835.8	50,785.5
2104	Хангамж, бараа материалын зардал	35,446.7	45,690.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,248.5	24,999.7
2107	Томилот, зочны зардал	5,281.5	11,118.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,105.8	453,059.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,044.3	30,646.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,177.5	16,028.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	428,759.2	462,976.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	218,797.0	338,205.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	218,797.0	338,205.8
2200	Дотоод эх үүсвэрээр	218,797.0	338,205.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-218,797.0	-338,205.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-77,000.0	-23,000.0

23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	77,000.0	23,000.0
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	132,962.2	101,770.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	153,460.3	286,422.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	286,422.6	388,193.0

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	4,187,137.7	4,187,137.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,873.4	12,873.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,200,011.0	4,200,011.0
9	Тайлант үеийн үр дүн	-2,258,001.7	-2,258,001.7
10	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,942,009.4	1,942,009.4
11	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	1,942,009.4	1,942,009.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	27,813.3	27,813.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,969,822.6	1,969,822.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-27,813.3	-27,813.3
19	Тайлант үеийн үр дүн	227,613.7	227,613.7
20	<b>2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	2,169,623.0	2,169,623.0

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,797,972.50</b>	<b>1,499,869.41</b>	<b>298,103.09</b>	<b>83.42</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,269,620.10</b>	<b>1,145,901.78</b>	<b>123,718.32</b>	<b>90.26</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,253,591.40</b>	<b>1,129,873.08</b>	<b>123,718.32</b>	<b>90.13</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	482,620.80	455,972.99	26,647.81	94.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,290.70	57,086.83	3,203.87	94.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	494,830.40	406,644.15	88,186.25	82.18
2104	Хангамж, бараа материалын зардал	46,805.20	45,690.29	1,114.91	97.62

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	84,339.60	84,088.45	251.15	99.70
2107	Томилолт, зочны зардал	11,150.00	11,118.00	32.00	99.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,665.20	38,625.52	4,039.68	90.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,889.50	30,646.85	242.65	99.21
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,028.70</b>	<b>16,028.70</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,028.70	16,028.70	0.00	100.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>404,152.40</b>	<b>330,967.63</b>	<b>73,184.77</b>	<b>81.89</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙН ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>124,200.00</b>	<b>23,000.00</b>	<b>101,200.00</b>	<b>18.52</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,797,972.50</b>	<b>1,554,520.86</b>	<b>243,451.64</b>	<b>86.46</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ТӨСӨВТ</b>	<b>1,420,008.50</b>	<b>1,464,389.03</b>	<b>-44,380.53</b>	<b>103.13</b>
<b>35</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>377,964.00</b>	<b>90,131.82</b>	<b>287,832.18</b>	<b>23.85</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	83,651.92	-83,651.92	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	141,303.36	-141,303.36	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0.00</b>
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	0	0.00
62	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25	0	0.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,724.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,724.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,724.93</b>
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний бусад төлбөр хураамжийн зардал	1,724.93
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,724.93</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,724.93

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, залруулагдаагүй нийт **1,525.0** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчил арилгуулах 1,525.0 мянган төгрөгийн ХХС-ийн авлагатай холбоотой болон орлоготой холбоотой 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 1,525.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 17,967.7 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.3.1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 2 нэр төрлийн орлого 1,525.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.8-т “түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр”, 23.8.14 “Газрын төлбөр”, 23.8. 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах

***Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.***

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 11 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлоготой холбоотой	1	1,525.0	-	-	-	-	1	1,525.0	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1</b>	<b>1,525.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,525.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн данстай холбоотой	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-